

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХОЛБОГДОХ ШҮҮХЭЭР ХЯНАН
ХЭЛЭЛЦЭГДЭЖ БАЙГАА 2019 ОНЫ ХЭРЭГ МАРГААНЫ ТАЛААРХ СУДАЛГАА**

2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар

А. Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох 2019 онд шүүхэд хэлцэгдэж буй хэрэг, маргаан:

№	Шүүхийн нэр	Нэхэмжлэл гаргасан хугацаа	Хэргийн товч утга	Нэхэмжлэгч ИТ-ийн нэр	Хариуцагч ИТ-ийн нэр	Анхан шатны шүүхийн шийдвэр	Давж заалдах шатны магадлал	Хяналтын шатны шүүхийн тогтоол	Тайлбар үр дүн
Иргэний хэргийн анхан шатны шүүх									
1	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.09.19	Захиалагч гүйцэтгэгч нарын хооронд 2011 оны 04 дүгээр сард байгуулсан №ИНЕГ, ТББ/БУ-5607 тоот гэрээгээр Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг гүйцэтгэх гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс 2014, 2015, 2016, 2017 онуудад асфальтобетон заводаа ажиллуулж олох байсан 4 705 118 456 37 /дөрвөн тэрбум долоон зуун таван сая нэг зуун арван найман мянга зуун тавин зургаан төгрөг, гучин долоон мөнгө/ төгрөгний хохиролыг ИНЕГ-аас гаргуулах тухай	Хурдны зам ХХК	Иргэний нисэхийн ерөнхий газар Бие даасан шаардлага гаргаагүй 3-дагч этгээдээр ЗТХЯ Б.Байгалмаа С.Мяндасмаа	1. “Хурдын зам”ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний нисэхийн ерөнхий газарт холбогдох иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаанд Зам тээврийн хөгжлийн яам бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдэр оролцож /итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Мяндасмаа, Б.Байгалмаа/ нар 2018.09.05-ны өдөр шүүх хуралдаанд оролцов. Хариуцагч ИНЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй тул гуравдагч этгээд хариуцагчийн эрх ашгийн хамгаалж шүүх хуралдаанд оролцов. Нэхэмжлэгчийн 2014, 2015, 2016, 2017 онуудад асфальтобетон заводаа ажиллуулж олох байсан 4,705,118,456.37 төгрөг гаргуулах шаардлага бүхий нэхэмжилснээс 4,3 тэр бум төгрөгний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Иргэний нисэхийн ерөнхий газар, Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг хамгаалж оролцсон. 2. Нэхэмжлэлтэй Иргэний хэргийн анхан шатны шүүх хурал 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр болж шүүгч нэхэмжлэгчийн шаардлагыг гарах ёстой зардал гарсан байна гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагаас 1 тэрбум төгрөгийн үнийн дүнг хангаж шийдвэрлэв.	Нийслэлийн давж заалдах шатны шүүх хуралдаан 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болж анхан шатны шүүхийн шийдвэрийгхэрэ гсэхгүй болгон, дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд хэргийг буцаахаар шийдвэрлэсэн.	Хяналтын шатны шүүхийн 06 дугаар сарын 14-ны өдрийн шүүх хуралдаанаар Нийслэлийн Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, анхан шатны шүүхэд хэргийг буцааж шийдвэрлэв.	Хэрэг анхан шатны шүүхэд буцан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.

2.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2018.04.02	<p>Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 22.86 км асфальтобетон хучилттай авто замын барилгын ажлын урьчилгаа төлбөр 663,480,000 /Зургаан зуун жаран гурван сая дөрвөн зуун наян мянга/төгрөг гаргуулах тухай</p> <p>/Талууд 2007 оны №2007-АЗБ-28/ тоот Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 22.86 км асфальтобетон хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгүүлэхээр гэрээний нийт дүн 22 211 600 000 төгрөг/ үүнээс урдчилгаа 663,480,000 төгрөг шилжүүлсэн ч гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс гэрээг цуцалсан/</p>	ЗТХЯ Б.Байгалмаа С.Мяндасмаа	“Нутгийн зам групп” ХХК	Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлтэй Нутгийн зам групп ХХК-д холбогдох Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 22.86 км асфальтобетон хучилттай авто замын барилгын ажлын урьчилгаа төлбөр 663,480,000 /Зургаан зуун жаран гурван сая дөрвөн зуун наян мянга/төгрөггаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийн шүүх хурал 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр болж хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон.	Давж заалдах шатны шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн магадлалаар нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангахгүй шийдвэрлэсэн.	Хяналтын шатны шүүх хуралдаан товлогдоогүй байна.	2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 1216 дугаар магадлалыг эс зөвшөөрч Нийслэлийн хяналтын шатны шүүхэд хандан гомдлыг итгэмжлэгдсэн төлөөлөгч нар 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүллээ.
3.	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.12.16	“Монголын төмөр зам” ТӨХК-тай байгуулсан 2011 оны 1/002 тоот гэрээний дагуу Даланзадгад-Тавантолгой-Цагаан суварга-Сайншанд-БаруунУрт- Хөөт-Чойбалсан чиглэлд барих төмөр замын 1165 км трассын дагуух инженер-геологи, геотехник, гидрологийн судалгааны ажлын төсөвт өртгийн үйлдэгдэл	Нэхэмжлэгч Эко Гидро Гео ХХК	Хариуцагч “Монголын төмөр зам” ТӨХК Монгол Улсын Хөгжлийн банк Гуравдагч этгээдээр Зам, тээврийн хөгжлийн яам С.Мяндасмаа	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			

			2,683,577,500 төгрөг гаргуулах						
4	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2016.11.08	<p>“Өндөрхаан-Чойбалсан” чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгч “Чайна гео инженеринг корпорациас 10,945,921,481 төгрөгийн хохирол гаргуулах тухай</p> <p>Талуудын хооронд 2013 оны 05 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан №83 тоот гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн хохирол гаргуулах талаар</p>	ЗТХЯ Г.Очхүү Б.Цэнд	“Чайна гео инженеринг корпораци” ХХК	<p>Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосныг нэхэмжлэгч тал эс зөвшөөрч Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан</p> <p>Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж хариуцагч “Чайна гео инженеринг корпораци” ХХКийн сөрөг нэхэмжлэлийн шаардлага болох сөрөг нэхэмжлэлийн шаардлага болох 3.050.175.738 төгрөгийг гаргуулж хариуцагчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 18.367.631 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, нэхэмжлэгчээс 15.408.828.69 төгрөгийг гаргуулж хариуцагчид олгохоор шийдвэрлэв.</p>	Давж заалдах шатны шүүхийн 2018.07.20-ны өдрийн шүүх хуралдаанаар Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Анхан шатны шүүхэд хэргийг буцаагаад байна.	<p>Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг нэхэмжлэгч “Чайна гео инженеринг корпораци” ХХКнь эс зөвшөөрч Хяналтын шатанд гомдол гаргасан.</p> <p>Хяналтын шатны шүүхуурал 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж хариуцагчийн гаргасан Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулах гомдлыг үндэслэлгүй гэж үзэн Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, анхан шатны шүүхэд хэргийг буцааж шийдвэрлэв.</p>	

5	Хан-Уул дүүргийн анхан шатны шүүх	2019.04	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн автобусыг Аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой төлбөр гаргуулах тухай</p> <p>Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд 2009 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 004 дугаар гэрээ,</p> <p>Нэхэмжлэлийн үнийн дүн 468,260.7 төгрөг</p>	<p>Зам, тээврийн хөгжлийн яам</p> <p>Г.Очхүү Б.Цэнд</p> <p>Нийслэлийн тээвэр үйлчилгээний газар</p> <p>Нийслэлийн өмчийн ашиглалтын газар</p>	“Атибус” ХХК	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			
6	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2019.03	<p>Хархорин-Хужирт” чиглэлийн 36,8 км хатуу хучилттай авто замын хоёрдугаар хэсэг 15,4 км замын барилгын ажил”-ыг гүйцэтгэх гэрээний урьдчилгаа төлбөр болох 276,000,000 /хоёр зуун далан зургаан сая төгрөг /-ийг гаргуулах тухай</p> <p>Талууд 2006 оны 12 дугаар сарын 18-нийөдрийн №АЗБ-06-03 дугаар гэрээ байгуулсан.Гэрээний нийт дүн 2 421 933 016 төгрөг үүнээс гэрээний үүргээ биелүүлээгүйтэй холбогдуулан</p>	<p>Зам, тээврийн хөгжлийн яам</p> <p>Г.Очхүү Б.Цэнд</p>	<p>Аваргас</p> <p>ХХК-ийн захирал</p> <p>Г.Чинбат</p>	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			

			гэрээг урдчилгаа төлбөрийг гаргуулах тухай						
7	Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2019.05	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн автобусыг Аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой төлбөр гаргуулах тухай Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд 2009 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 004 дугаар гэрээ, Нэхэмжлэлийн үнийн дүн 3.862.432,6 төгрөг	Зам, тээврийн хөгжлийн яам Г.Очхүү Б.Цэнд Нийслэлийн тээвэр үйлчилгээний газар Нийслэлийн өмчийн ашиглалтын газар	"Тэнүүн-Огоо" ХХК				Хурал 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр товлогдож хариуцагчийн хүсэлтээр хойшлогдож 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зарлагдсан. нэхэмжлэгч Өмчийн харилцааны удирдлагын газрын итгэмжлэгсэн төлөөлөгчийн өмгөөлөгч авах хүсэлтийн дагуу хойшлогдов.
8	Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2019.05	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн автобусыг Аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой төлбөр гаргуулах тухай Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд 2009 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 004	Зам, тээврийн хөгжлийн яам Г.Очхүү Б.Цэнд Нийслэлийн тээвэр үйлчилгээний газар Нийслэлийн өмчийн ашиглалтын газар	Сутайн буянт ХХК	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			.

			дугаар гэрээ, Нэхэмжлэлийн үнийн дүн 2,043,770,2 төгрөг						
9	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2019.05	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн автобусыг Аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой төлбөр гаргуулах тухай Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд 2009 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 004 дугаар гэрээ, Нэхэмжлэлийн үнийн дүн 584,565.0 төгрөг	Зам, тээврийн хөгжлийн яам Г.Очхүү Б.Цэнд Нийслэлийн тээвэр үйлчилгээний газар Нийслэлийн өмчийн ашиглалтын газар	Мяралзаа ХХК	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			
10	Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2019.05	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн автобусыг Аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой төлбөр гаргуулах тухай Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд 2009 оны 07 дугаар сарын	Зам, тээврийн хөгжлийн яам Г.Очхүү Б.Цэнд Нийслэлийн тээвэр үйлчилгээний газар Нийслэлийн өмчийн ашиглалтын газар	Автобус нэгдэл ХХК	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			

			29-ний өдөр байгуулсан 004 дугаар гэрээ, Нэхэмжлэлийн үнийн дүн 649,401.1 төгрөг						
11	Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2019.05	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн автобусыг Аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой төлбөр гаргуулах тухай Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд 2009 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 004 дугаар гэрээ, Нэхэмжлэлийн үнийн дүн 2,168,197,7 төгрөг	Зам, тээврийн хөгжлийн яам Г.Очхүү Б.Цэнд Нийслэлийн тээвэр үйлчилгээний газар Нийслэлийн өмчийн ашиглалтын газар	Эрдэм Транс ХХК	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.			

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ

1	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2017.07.29	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өргөрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулж, нөхөн төлбөр	“Жуулчин монгол наадам” ХХК	Засгийн газар, Барилга, хот байгуулалтын яам, ЗТХЯ С.Мяндасмаа	Анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн шүүх хуралд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс “Хэргийн газрын үзлэг хийлгэх хүсэлт” гаргаж шүүх хурал хойшлогдоод байна. “Жуулчин монгол наадам” ХХК-ийн нэхэмжлэлтэй Засгийн газар, Барилга хот байгуулалтын яаманд холбогдох гуравдагч этгээдээр ЗТХЯ оролцсон захиргааны хэргийн шүүх хурал 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр болж Засгийн газрын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэв .	Нийслэлийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 07 дугаар сарын 18-ны хуралдаанаар 128/Ш32018/410 0 дугаар захирамжийг хэвээр үлдээв.	“Жуулчин монгол” ХХК-ийн “Монгол улсын Засгийн газрын 2010 оны “Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай” 140 дүгээр тогтоол, 2016 оны “Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай” 154 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдох	
---	--	------------	--	-----------------------------	---	--	---	--	--

			гаргуулах тухай					захиргааны хэрэгт хариуцагч Засгийн газрыг төлөөлж, Улсын дээд шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн шүүх хуралдаанд оролцож ““Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаах” тухай шийдвэр гарсан.	
2	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.01.19	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016.03.14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өөртөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулж, нөхөн төлбөр гаргуулах тухай	“Ашид арвин буян” ХХК	Засгийн газар С.Мяндасмаа	1.Нэхэмжлэгч “Ашид арвин буян” ХХК-ийн нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдох “Засгийн гакрын 2010 оны 140, 2015 оны 154 дүгээр тогтоолын өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралд хариуцагч Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, нотлох баримт дахин бүрдүүлэх үндэслэлээр хойшлогдов.			
3	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.06.05	ЗГ-ын 2010 оны газрын тусгай хэрэгцээнд авах тухай тогтоолын өөрт хамаарах хэсгийг хүчингүй болгох тухай	Оточ-Уул ХХК	Засгийн газар С.Мяндасмаа	Нэхэмжлэгч “Очот-Уул” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагын хариу тайлбарыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хариуцагч Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд гаргаж хүргүүлсэн.			

4	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.06.20	“2016, 2017 онд Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км авто замын барилгын ажилд тавигдсан техникийн хяналт буюу зөвлөх үйлчилгээний зардал болох нийт 1.325.000.013 төгрөг төлөхгүй, хугацаа алдагдуулж байгаа Зам, тээврийн хөгжлийн яамны эс үйлдлийг хууль бус болохыг тогтоох, 2016, 2017 оны замын барилгын ажилд байнгын техник-технологийн хяналтын ажлын нийт үнэ 1.325.000.013 төгрөгний төлбөр гаргуулах тухай	Эм Си Пи Си Жи Ар ХХК	ЗТХЯ Б.Байгалмаа, С.Мяндасмаа	1.Эм Си Ри Си Жи Ар ХХК-ийн “2016, 2017 онуудад Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн замын барилгын ажилд тавигдсан техникийн хяналт буюу зөвлөх үйлчилгээний зардал болох нийт 1.325.000.013 төгрөг төлөхгүй, хугацаа алдагдуулж байгаа Зам, тээврийн хөгжлийн яамны эс үйлдлийг хууль бус болохыг тогтоох, 2016, 2017 оны замын барилгын ажилд байнгын техник-технологийн хяналтын ажлын нийт үнэ 1.325.000.013 төгрөгний төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлтэй Зам, тээврийн хөгжлийн яамтай холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хурал захиргааны хэргийн шүүхэд 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр болж нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хангаж, анхан шатны шүүхийн шийдвэр “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ны талд шийдвэрлэгдсэн.	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 128/ШШ2018/08 37 дугаар хүчингүй болгож, хэргийг анхан шатны журмаар хэлэлцүүлэхээр буцаасан.	Хяналтын шатны шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй үлдээж хэргийг анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.	Хэрэг анхан шатны шүүхэд буцан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.
6	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2019.1.18	Ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай	Иргэн С.Дорждагва	ЗТХЯ Б.Цэнд Г.Очхүү				
7	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2019.05	Зтхсайдын 2018 оны 08 дугаар сарын 32-ний өдрийн 190 тоот тушаал, 2018 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 159 тоот тушаалын “Билэ”г ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	Мах импекс ХХК	Б.Билгүүн				Нэхэмжлэлийн хувийг гардан авч хариу тайлбар хүргүүлсэн.
8.	Нийслэлийн захиргааны	2019.09	Зам, тээврийн хөгжлийн сайдын	Изинис	Б.Байгалмаа	Нэхэмжлэлийн хувийг 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр гардан авч			

	хэргийн анхан шатны шүүх		2019 оны 250 дугаар тушаалын 2 дахь заалтыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох	Эйрвэйз" ХХК	Б.Цэнд	хариу тайлбарыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 09 дүгээр сарын 18-нд хүргүүлсэн. Урьдчилсан хэлэлцүүлэг 2019 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 11.30-д зарлагдаад байна.			
--	--------------------------	--	---	--------------	--------	---	--	--	--

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХОЛБОГДОХ
2019 ОНД ШҮҮХЭЭР ХЭЛЭЛЦЭГДЭЖ ДУУСГАВАР БОЛСОН ХЭРГИЙН СУДАЛГАА**

Б. Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох 2019 онд шүүхээр хэлцэгдэж дуусгавар болсон хэрэг, маргаан:

Иргэний хэргийн анхан шатны шүүх

1.	Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх	2017.06.15	Ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай	Иргэн Д.Цогням	ЗТХЯ С.Мяндасмаа Б.Байгалмаа			Улсын дээд шүүхэд шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай нэхэмжлэгч Иргэн Д.Цогнямын хүсэлтийн дагуу Улсын дээд шүүх 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж хүсэлтийг хангахгүй орхиж, Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг хамгаалж шийдвэрлүүлсэн.	
2	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2018.09.17	Баян-Өлгий аймгийн Толбо сумын нутагт Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төслийн хүрээнд баригдсан 60 км хатуу хучилттай авто зам барих хүрээнд Чайна Хуашин Энтерпрайзиз ХХК, ЗТХЯ-ны буруутай үйл ажиллагаанаас болж өөрт учирсан гэм хор болох 10,000,000 сая төгрөг гаргуулах тухай	Баян-Өлгий аймгийн иргэн Н.Манатхан	Чайна Хуашин Энтерпрайзиз ХХК, ЗТХЯ Б.Цэнд Б.Байгалмаа	Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-ийг баримтлан хариуцагч “Чайна Хуашин Энтерпрайзиз” ХХК, ЗТХЯ-иас гэм хорын хохиролд 10.000.000 төгрөг гаргуулах тухай Н.Манатаны нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.			
	Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.09.07	Зам, тээвэр барилга, хот байгуулалтын яам, “Цахилгаан тээвэр”	Зам тээврийн хөгжлийн яам	Зорчигч тээврийн нэгтгэл	Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлтэй Зорчигч	Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 01		

3			ОНӨААТҮГ-тай /хуучнаар/ байгуулсан “Цахилгаан тээврийн хэрэгсэл-12 ширхэг Доубус угсрах” ЦТХ-ДУ 2011/01/72 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдэх 12 дуобуснаас нийлүүлэгдээгүй үлдсэн 2 доубусны үнэ болох 322,934,167.00 /гурван зуун хорин хоёр сая есөн зуун гучин дөрвөн мянга зуун жаран долоо/ төгрөг, алданги 161,467,083.00 /нэг зуун жаран нэгэн сая дөрвөн зуун жаран долоон мянга наян гурав/ төгрөгийг гаргуулах	Г.Очхүү	ОНӨААТҮГ	тээврийн нэгтгэлд холбогдох Иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 14 цаг 00 минутад хуралдаж Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.3-д заасны дагуу бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.	дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар Зам, тээврийн яамны нэхэмжлэлтэй Цахилгаан тээвэр ТӨҮГ-т холбогдох “добусны үнэ болох 322,934,167.00 төгрөг, алданги 161,467,083.00 төгрөгийг гаргуулах тухай” иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчид оролцож, нэхэмжлэлийн шаардлагын 322,934,167.00 төгрөгийг хангаж шийдвэрлэсэн.	-Хурал УДШ-ийн Иргэний хэргийн танхимд 2019 оны 05 дугаар 16-ны өдөр болж “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-с 237,942,166 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Зам, тээврийн хөгжлийн яаманд олгохоор шийдвэрлэсэн.
---	--	--	---	---------	----------	--	---	---

Захиргааны хэргийн шүүх

1	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.10.29	Ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай	Иргэн Ю.Артур	ЗТХЯ С.Мяндасмаа	Ю.Артурын нэхэмжлэлтэй, ЗТХЯ-д холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр болж Ю.Артурын гарын үсгийг шинжлэн судлуулахаар шинжээч томилохоор шүүгч шийдвэрлэв. Шүүх хуралдаан жич хугацаагаар хойшлогдов.			- 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 11 цаг 30 минутад шүүх хурал болж Нэхэмжлэгч Ю.Артурын нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Давж заалдах гомдол гаргаж удирдлагуудад танилцуулсан.
2	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2019.04	Сонгон шалгаруулалтыг хүчингүй болгуулах тухай	Иргэн Р.Мэргэн	ЗТХЯ Б.Цэнд Г.Очхүү	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэгч Р.Мэргэний нэхэмжлэлийг бүхэлд нь			

						хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.			
3	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2018.3.16	Засгийн газрын 2017оны 277 дугаар тогтоолын өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах /Иргэний нисэхийн катерингийн үйлчилгээтэй холбоотой/	“Нүхт тур”	Засгийн газар, Үндэсний хөгжлийн газар Г.Очхүү	Нүхт тур ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газар, Үндэсний хөгжлийн газарт холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 09 цагт хуралдаж Нүхт тур ХХК-ийн гаргасан нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.14-т заасны дагуу нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлж, Засгийн газрын эрх ашгийг хамгаалж оролцов.	Нүхт тур” ХХК-ийн гаргасан нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.14 дэх хэсгийг үндэслэн бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээн шийдвэрлэсэн.		
	Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх	2019.09.15	Засгийн газарт холбогдуулан гаргасан “Алтанбулаг-Улаанбаатар-Замын -Үүд” чиглэлийн хурдын зам барих-ашиглах-шилжүүлэх” концессийн гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн Засгийн газрын 2019 оны 241 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах тухай	Чингис ленд деволмент групп-Шинэ хөгжлийн зам” групп” ХХК	Засгийн газар С.Мяндасмаа	Нэхэмжлэгч Чингис ленд деволмент групп-Шинэ хөгжлийн зам” групп” ХХК нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдуулан гаргасан “Алтанбулаг-Улаанбаатар-Замын -Үүд” чиглэлийн хурдын зам барих-ашиглах-шилжүүлэх” концессийн гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн Засгийн газрын 2019 оны 241 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой захиргааны хэргийг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хэлэлцэж “хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож” шийдвэрлэсэн.			

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХОЛБОГДОХ ШҮҮХЭЭР ХЯНАН
ХЭЛЭЛЦЭГДЭЖ БАЙГАА 2019 ОНЫ ХЭРЭГ МАРГААНЫ ТАЛААРХ СУДАЛГАА**

2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

1.Зам, тээврийн хөгжлийн яамны хэмжээнд 2019 онд хэрэг маргааны судалгаанд 25 хэрэг байна. Үүнд:

Иргэний **14** хэрэг
Захиргааны **10** хэрэг байна.

Үүнээс ангилвал:

Засгийн газрыг төлөөлж оролцож байгаа **4** хэрэг,
ЗТХЯ-г төлөөлж **20** хэрэг байна.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийт 18 хэрэг байна.

Иргэний **11** хэрэг
Захиргааны **7** хэрэг байна.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон 7 хэрэг байна.

Иргэний **3** хэрэг
Захиргааны **4** хэрэг байна.

Хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагааны талаарх мэдээлэл:

1. Эм Си Пи Си Жи Ар ХХК-ийн нэхэмжлэлтэй Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох “2016, 2017 онд Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км авто замын барилгын ажилд тавигдсан техникийн хяналт буюу зөвлөх үйлчилгээний зардал болох нийт 1.325.000.013 төгрөг төлөхгүй, хугацаа алдагдуулж байгаа Зам, тээврийн хөгжлийн яамны эс үйлдлийг хууль бус болохыг тогтоох, 2016, 2017 оны замын барилгын ажилд байнгын техник-технологийн хяналтын ажлын нийт үнэ 1.325.000.013 төгрөгний төлбөр гаргуулах тухай захиргааны хэргийн шүүх хурал 11 дүгээр сарын 11-ний өдөр захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал болж нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

2. Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 400 автобусыг нийлүүлэхтэй холбоотой гэрээний үүргийн дагуу хариуцагч “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т холбогдуулан гаргасан нэхэмжлэлтэй иргэний хэргийн хурал 2019 оны 11 дүгээр сарын 28-нд зарлагдаж хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгч авах хүсэлтийг шүүхээс хангаж хурал 2019.12.11-нийт өдөр хүртэл хойшлогдов.

3. “Изинис эйрвайз” ХХК-ийн нэхэмжлэлтэй Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 250 дугаар тушаалыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй захиргааны хэргийн хурал 2019.11.25-ны өдөр зарлагдаж шүүхээс нотлох баримтыг хөндлөнгийн байгууллагаар батлагаажуулах шаардлагтай гэсэн үндэслэлээр хурлыг 2019.12.09-ны өдөр хүртэл хойшлуулж шийдвэрлэсэн.

4. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 355 дугаар тушаалыг хууль бус болохыг тогтоолгох тухай иргэн С.Дорждагвын нэхэмжлэлтэй захиргааны хэргийн хурал 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр хуралдаж нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг шүүхээс хангаж шийдвэрлэсэн.

5. Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 400 автобусыг нийлүүлэхтэй холбоотой гэрээний үүргийн дагуу хариуцагч “Атибус” ХХК-д холбогдуулан гаргасан нэхэмжлэлтэй иргэний хэргийн хурал 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр зарлагдаж хариуцагчийн хүсэлтээр хурлыг 2019.12.10-ны өдрийг хүртэл хойшлуулав.

6. Хурдны зам ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний нисэхийн ерөнхий газарт холбогдох Захиалагч гүйцэтгэгч нарын хооронд 2011 оны 04 дүгээр сард байгуулсан №ИНЕГ, ТББ/БУ-5607 тоот гэрээгээр Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг гүйцэтгэх гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс 2014, 2015, 2016, 2017 онуудад асфальтобетон заводаа ажиллуулж олох байсан 4 705 118 456 37 /дөрвөн тэрбум долоон зуун таван сая нэг зуун арван найман мянга зуун тавин зургаан төгрөг, гучин долоон мөнгө/ төгрөгний хохиролыг ИНЕГ-аас гаргуулах тухай нэхэмжлэлтэй Иргэний хэргийн анхан шатны шүүх хурал 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр болж шүүгч нэхэмжлэгчийн шаардлагыг гарах ёстой зардал гарсан байна гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагаас 1 тэрбум төгрөгийн үнийн дүнг хангаж шийдвэрлэв.

7. Нэхэмжлэгч Чингис ленд деволмент групп-Шинэ хөгжлийн зам” групп” ХХК нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдуулан гаргасан “Алтанбулаг-Улаанбаатар-Замын -Үүд” чиглэлийн хурдын зам барих-ашиглах-шилжүүлэх” концессийн гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн Засгийн газрын 2019 оны 241 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой захиргааны хэргийг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хэлэлцэж “хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож” шийдвэрлэсэн.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон Иргэн, Захиргааны хэргийн талаарх мэдээлэл:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлтэй Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-д холбогдох Зам, тээвэр барилга, хот байгуулалтын яам, “Цахилгаан тээвэр” ОНӨААТҮГ-тай /хуучнаар/ байгуулсан “Цахилгаан тээврийн хэрэгсэл-12 ширхэг Доубус угсрах” ЦТХ-ДУ 2011/01/72 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдэх 12 доубуснаас нийлүүлэгдээгүй үлдсэн 2 доубусны үнэ болох 322,934,167.00 /гурван зуун хорин хоёр сая есэн зуун гучин дөрвөн мянга зуун жаран долоо/ төгрөг, алданги 161,467,083.00 /нэг зуун жаран нэгэн сая дөрвөн зуун жаран долоон мянга наян гурав/ төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимд 2019 оны 05 дугаар 16-ны өдөр болж “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-с 237,942,166 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Зам, тээврийн хөгжлийн яаманд олгохоор шийдвэрлэсний дагуу Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх Гүйцэтгэх хуудас гаргуулахаар 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдөр хүсэлт гаргаад шүүгчийн захирамж албажиж гараагүй байна.

2. Баян-Өлгий аймгийн иргэн Н.Манатханы нэхэмжлэлтэй Чайна Хуашин Энтерпрайзиз ХХК, Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох Баян-Өлгий аймгийн Толбо сумын нутагт Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төслийн хүрээнд баригдсан 60 км хатуу хучилттай авто зам барих хүрээнд Чайна Хуашин Энтерпрайзиз ХХК, ЗТХЯ-ны буруутай үйл ажиллагаанаас болж өөрт учирсан гэм хор болох 10,000,000 сая төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийн 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн анхан шатны шүүх хуралдаанаар гэм хорын хохиролд 10.000.000 төгрөг гаргуулах тухай Н.Манатаны нэхэмжлэлийг бүхэлд хэрэгсэхгүй болгож Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг бүхэлд нь хамгаалж шийдвэрлүүлсэн.

3. Иргэн Д.Цогнямын нэхэмжлэлтэй Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох Ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг Улсын дээд шүүхэд шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай нэхэмжлэгч Иргэн Д.Цогнямын хүсэлтийн дагуу Улсын дээд шүүх 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хүсэлтийг хангахгүй орхиж, Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг хамгаалж шийдвэрлүүлсэн.

4. Иргэн Ю.Артурын нэхэмжлэлтэй, ЗТХЯ-д холбогдох ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал Захиргааны хэргийн анхан шатны шүүх танхимд 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 11 цаг 30 минутад шүүх хурал болж Нэхэмжлэгч Ю.Артурын нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

5. Иргэн Р.Мэргэн нэхэмжлэлтэй, Төрийн албаны зөвлөл, Хэрэг эрхлэх газар, Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал Захиргааны хэргийн анхан шатны шүүх танхимд 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 11 цаг 30 минутад хуралдаж Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэгч Р.Мэргэний нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

6. Нэхэмжлэгч Чингис лэнд деволмент групп-Шинэ хөгжлийн зам” групп” ХХК нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдуулан гаргасан “Алтанбулаг-Улаанбаатар-Замын -Үүд” чиглэлийн хурдын зам барих-ашиглах-шилжүүлэх” концессийн гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн Засгийн газрын 2019 оны 241 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой захиргааны хэргийг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хэлэлцэж “хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож” шийдвэрлэсэн.

Боловсруулсан:Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Байгалмаа